



ХӨДӨЛМӨРИЙН ГАВЬЯАНЫ
УЛААН ТУГИЙН ОДОНТ
АРЬСНЫ ӨВЧИН СУДЛАЛЫН
ҮНДЭСНИЙ ТӨВ

Цагдаагийн гудамж 78, 7 дугаар хороо,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14171
Утас: (976-11) 35 02 54, 35 02 52.
Цахим шуудан: info@derma.gov.mn,
Цахим хуудас: www.derma.gov.mn


2024.06.20 № 01/294
танай 2024.06.19-ны № 2/2695 -т

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМАНД

Эрүүл мэндийн салбарт хэрэгжиж буй хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг 2024 оны эхний хагас жилийн байдлаар шинэчилсэн жагсаалтын дагуу холбогдох заалтын биелэлтийг хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт 40 хуудастай.

ЗАХИРАЛ *Ц.Уранчимэг* Ц.УРАНЧИМЭГ



1424030133

D:\АӨСҮТ\Албан бичиг\A5.docx

Арьсны өвчин судлалын үндэсний төвийн
 2024 оны 06 дугаар сарын 20-ний өдрийн
 01/294 дугаар албан бичгийн хавсралт



Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт
Арьсны өвчин судлалын үндэсний төв
2024 оны эхний хагас жил

Шийдвэр Д/д	Заалт Д/д	Шийдвэрийн нэр, огноо, дугаар	Холбогдох заалтын агуулга	Хэрэгжилтийн явц	Үнэлгээний хувь
МУ-ын хууль					
14	31	Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль 2021-12-24 Дугаар 2021-12-24	16.1.12. Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн үйл ажиллагааны тайланг жил бүр; (16.1.Улсын Их Хурал дараах тайлан, илтгэл, мэдээллийг хуульд заасан хугацаанд нээлттэй болон хаалттай хэлэлцэнэ:)	Хамаарахгүй	
16	33	Төрийн хэмнэлтийн тухай 2022-04-29 Дугаар 2022.04.29	13.1.2. энэ хуулийн 13.1.1-д заасан хугацаанд худалдан авах ажиллагааг зохион байгуулж дуусгаагүй бол төсөл, арга хэмжээний санхүүжилтийг төсвийн хэмнэлтэд тооцох; (13.1.1. батлагдсан төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг жил бүрийн 05 дугаар сарын 31-ний өдрийн дотор бүрэн дуусгах; 22.1. Энэ хуулийн 13.1.1, 13.1.2 дахь заалтыг 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.)	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж төвийн захирлаар батлуулж, батлагдсан төлөвлөгөөний дагуу тайлант хугацаанд нийт эм, эмнэлгийн хэрэгсэл, багаж техник хэрэгсэл, хоол хүнсний материал худалдан авах ажиллагааг цахим хэлбэрээр зохион байгуулан, үнийн саналын нээлтийг хийж үнэлгээг хийж захиалагчид зөвлөмж хүргүүлэн ажилласан. 2024 онд хоол хүнсний материалын тендерт 3 багц зарлаж нийт 7 аж ахуйн нэгж орж ирснээс 3 байгууллагатай 262,7 сая төгрөгийн гэрээ байгуулсан. 1 дүгээр улиралд журмын дагуу худалдан авах ажиллагааг төлөвлөн худалдан авах ажиллагааг эхлүүлсэн.	

				Тендерийн урилгыг http://tender.gov.mn/ сайт, байгууллагын цахим хуудас https://derma.gov.mn/ , өдөр тутмын “Өдрийн мэдээ” сонинд нийтэлж, тендерт оролцогч нарт шалгарсан болон шалгараагүй мэдэгдлийг албан бичгээр болон төрийн худалдан авалтын http://tender.gov.mn/ сайтад үнэлгээний хорооны нарийн бичиг тухай бүрд нь нийтлэн ажиллаж байна		
26	51	Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах талаар авах зарим арга хэмжээний тухай 2016-04-14 Дугаар 2016 №34	7. газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөлтийг боловсронгуй болгох, бэлэн байдлыг хангах, гамшгийн аюулыг эрт зарлан мэдээлэх тогтолцоог өргөтгөх, улсын болон байгууллага, аж ахуйн нэгжийн нөөцийн удирдлага, чадавхыг бэхжүүлэх, урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгааны ажлыг эрчимжүүлэх, төр, хувийн хэвшлийн түншлэл, иргэд, олон нийтийн байгууллагын хамтын ажиллагааг нэмэгдүүлэх;	Гамшгаас хамгаалах Мэргэжлийн ангийн бүтэц нь 2021 оны 01 дүгээр сарын 06-ний өдрийн захирлын тушаалаар шинэчлэн батлагдсан. 2021 оны 01 дүгээр сард төвийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөг шинэчлэн батлуулсан. 2024 оны Газар хөдлөлтийн аюулаас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах ажилд нийт албан хаагчдыг хамруулж, идэвхтэй оролцсон.		
	52		8. “Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө”-г батлан, төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний зардлыг жил бүрийн улсын төсөвт тусган шийдвэрлүүлж байх.	-		
28	54	Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан	1.2/. Иргэдийн эрүүл мэндэд учирч болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр Эрүүл мэндийн	Хамаарахгүй		

		сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах талаар чиглэл өгөх тухай 2020-12-03 Дугаар 2020 №36	даатгалын эрсдэлийн сан байгуулж удирдлагаар хангахыг Эрүүл мэндийн сайдад үүрэг болгох;			
	60		1.2/. Монгол хүний удмын санг цус ойртолт, удамшлын өвчлөлөөс сэргийлэх зорилгоор "Угийн бичиг"-ийг айл өрх бүрд шинжлэх ухааны үндэслэлтэйгээр хөтлүүлэн хэвшүүлэх ажлыг орон даяар 2024 онд багтаан хэрэгжүүлэх, шаардлагатай бол холбогдох судалгаанд тулгуурлан ургийн овгийн нэршлийг шинэчлэх арга хэмжээг зохион байгуулах;	Хамаарахгүй		
	62		1.4/. Монгол хүний удмын сангийн аюулгүй байдлыг хамгаалах чиглэлээр орчин үеийн дэвшилтэт технологи бүхий генетикийн лаборатори, гений сан байгуулах асуудлыг судлан шийдвэрлэх, шаардагдах төсвийг улсын төсвөөс санхүүжүүлэх;	Хамаарахгүй		
	64		1.6/. Монгол Улсын хүн ам, эдийн засаг, дэд бүтэц, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлттэй уялдуулан хот, хөдөөгийн хөгжлийн тэнцвэрийг хангах, төвлөрлийг сааруулах асуудлыг хөгжлийн зорилтот	Хамаарахгүй		

		хөтөлбөрт тусган хэрэгжүүлэх;			
67		6.б/. нийгмийн сүлжээний хяналтгүй хэрэглээнээс шалтгаалан цахим гадуурхалтад өртөх, хүүхэд дэлгэцийн хамааралтай болох, цахим гэмт хэргийн хохирогч болох, нас, сэтгэхүйн онцлогт үл тохирох, зүй бус агуулгатай контент үзэх, зан суртахуунд нь сөргөөр нөлөөлөх зэрэг эрсдэлийг бууруулахад чиглэсэн цогц арга хэмжээг авч хэрэгжүүлэх; (6/Эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийн талаар:)	Хамаарахгүй		
68		6.в/. сэтгэцийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тулгамдсан асуудалтай холбоотой сэтгэцийн эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, санхүүжилтийг нэмэгдүүлэх, эрх зүйн орчныг боловсронгуй болгох талаар зорилтот хөтөлбөр боловсруулах. (6/Эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийн талаар:)	Хамаарахгүй		
71		1.9. Эрүүл мэндийн даатгалын санд үүссэн өр төлбөрийг 2023 оны төсвийн жилд өр төлбөр үүсгэхгүйгээр барагдуулах арга хэмжээ авах;			

33	72	НҮҮРСНИЙ ТЭЭВЭРЛЭЛТ, ЭКСПОРТТОЙ ХОЛБООТОЙ АСУУДЛААРХ ЕРӨНХИЙ ХЯНАЛТЫН СОНСГОЛЫН ТАЙЛАНТАЙ ХОЛБОГДУУЛАН АВАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ 2023-01-19 Дугаар 2023 №08	З/в. Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмжид үндэслэн аж ахуйн болон хөрөнгө оруулалтын чиглэлийн аливаа оффтейк гэрээ байгуулахгүй байх, улсын нууцад хамааруулахгүй байх, шаардлагатай тохиолдолд Улсын Их Хуралд танилцуулж, хэлэлцүүлэх;	Хамаарахгүй		
34	73	Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь илтгэл, эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний	За/. ахмад настны тусламж үйлчилгээний нэгдсэн, цогц тогтолцоог бүрдүүлэх зорилтыг эрчимжүүлэх, насжилтын үеийн өвчний эрсдэлийг нэмэгдүүлдэг хүчин зүйлүүдийг бууруулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх;	Хамаарахгүй		
	74	тайланг хэлэлцсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай 2023-05-04 Дугаар 2023 №35	Зв/. ахмадын асрамж, хамгаалал, сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалах, чөлөөт цагаа өнгөрүүлэх орчин нөхцөлийг бий болгох асуудлаар цогц бодлого боловсруулж, хэрэгжүүлэх.	Хамаарахгүй		
35	75	ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ЁС ЗҮЙН ТУХАЙ ХУУЛЬ БАТАЛСАНТАЙ ХОЛБОГДУУЛАН АВАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ	1.3. төрийн албан хаагчийн Ёс зүйн дэд хороог байгуулах ажлыг мэргэжил, арга зүй, зохион байгуулалтын удирдлагаар хангаж, үйл ажиллагааг жигдрүүлэх.	АӨСҮТ-ийн Ёс зүйн салбар хороо нь нийт 7 хүний бүрэлдэхүүнтэй (Дарга-1, нарийн бичиг-1, гишүүн- 5) үйл ажиллагаа явуулж байна. Ёс зүйн салбар хороо нь 2024 оны төлөвлөгөөний дагуу албан хаагчдад 3 удаагийн сургалт зохион байгуулж, 1 иргэний гомдлыг шийдвэрлэн ажилласан.		

		ТУХАЙ 2023-05-04 Дугаар 2023_32				
36	76	АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР БАТЛАХ ТУХАЙ 2023-06-30 Дугаар 2023_59	3. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрт тусгагдсан зорилт, үйл ажиллагааг улсын болон аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгаж хэрэгжүүлэхийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн удирдлагад, хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах, нэгдсэн удирдлагаар ханган хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/, Авлигатай тэмцэх газар /З.Дашдаваа/-т тус тус үүрэг болгосугай.	Эрүүл мэндийн яамны 2024 оны 02 дугаар сарын 29-ний өдрийн 3/859 дугаар албан бичгийн хавсралтын дагуу “Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө”-г баталж, эхний хагас жилийн тайланг ЭМЯ-ны ЭБАТ-д 2024 оны 06 дугаар сарын 02-ний өдөр хүргүүлсэн.		
37	77	МОНГОЛ УЛСЫН 2024 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬ БАТАЛСАНТАЙ ХОЛБОГДУУЛАН АВАХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ 2023-11-10 Дугаар 2023_93	1.7. анхан шатны эрүүл мэндийн тусламж үйлчилгээний санхүүжилтийг бүс нутгийн онцлогийг харгалзан ялгаатай хуваарилах, иргэдийг тусламж үйлчилгээний шатлал хооронд хүнд суртал, чирэгдэлгүйгээр шуурхай шилжүүлдэг байх зэрэг зохицуулалтын оновчтой арга хэрэгслийг 2023 онд багтаан шийдвэрлэж, 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хэрэгжүүлэх;	Хамаарахгүй		
	78		1.8. өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх	-		

			үзлэг, шинжилгээ, оношилгоог үргэлжлүүлэн эрчимжүүлж, хөдөөгийн хүн амын хамрагдалтыг нэмэгдүүлэх аян зохион байгуулах;			
	79		1.10. төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх, хяналт тавих, ашиглалтад хүлээн авах, өмчид хүлээн авах үйл ажиллагаанд ногоон байгууламжийн стандарт болон тусгай хэрэгцээт иргэдийн хэрэгцээнд нийцсэн стандартыг чанд мөрдөж хэрэгжүүлэх, зохион байгуулах;	-		
38	80	Сүрьеэ, бэлгийн замаар дамжих халдварт өвчин, хүний дархлал хомсдолын вирусийн халдварын тархалтыг бууруулах, хязгаарлах, урьдчилан сэргийлэх талаар авах арга хэмжээний тухай 2016-04-05 Дугаар 2016 №10 НББСШУБХ	1.4. сүрьеэ, бэлгийн замаар дамжих халдвар, ХДХВ/ДОХ-оос урьдчилан сэргийлэх чиглэлийн мэдээлэл, сургалт, сурталчилгааг МҮОНРТ, Боловсрол суваг болон бусад радио, телевиз, сонин хэвлэл, нийгмийн сүлжээг ашиглан хүн амын дунд зохион байгуулах, үйл ажиллагааг эрчимжүүлэх;	-		
40	83	Засгийн газарт чиглэл өгөх тухай	1.7/. Цэцэрлэгийн хүүхдийн хоолны стандартыг			

		2017-07-05 Дугаар 2017 №25 НББСШУБХ	мөрдүүлж, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангаж, хяналт тавьж ажиллах;	Хамаарахгүй		
41	85	“Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 16 дахь илтгэл”-ийг хэлэлцсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай 2018-01-31 Дугаар 2018 №02 ХЗБХ	3.5.. Эрүүл мэндийн яам Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 27 дугаар зүйлд заасны дагуу эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх явцдаа хоширогчийг илрүүлэх, холбогдох байгууллагад мэдээлэх, хоширогчийн бэртэл гэмтэл, өвчлөлийн шалтгааныг тэмдэглэж, баримтжуулж, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан чиг үүргийн хэрэгжилтийг хангаж, ажиллах.	-		
43	87	Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2018-12-20 Дугаар 2018 №24 НББСШУБХ	1.12/. Агаарын болон орчны бохирдлоос хүүхдийн эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх, эрүүл мэндэд нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах талаар боломжит бүх арга хэмжээг эрүүл мэндийн байгууллагаас авч хэрэгжүүлэх;	-		
44	88	Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөлийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 2019-10-22 Дугаар 2019 №08 НББСШУБХ	2.. Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөлийн дүрмийн 2 дахь хэсгийн 2.6 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай: “2.6.Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 141.6-д заасны дагуу Үндэсний зөвлөлийн гишүүний ажлын оролцоог	Хамаарахгүй		

			харгалзан улирал тутам урамшуулал олгох бөгөөд урамшууллын дээд хэмжээг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр дахин нэмэгдүүлснээс ихгүй байхаар тогтоож, олгоно."			
47	91	Чиглэл өгөх тухай 2021-06-15 Дугаар 2021 №01 ИЦББХ	1. "Монгол Улсын Их Хурлын Инновац цахим бодлогын байнгын хорооны 2020 оны 02 дугаар тогтоолоор байгуулсан Ажлын хэсгийн хяналт шалгалтын тайланг хэлэлцээд дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн I газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай: 1/ Эрүүл мэндийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх хүрээнд хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөр арга хэмжээний хөрөнгө оруулалтын үр ашгийг судалж, төсвийн үр ашиггүй зардлыг бууруулах"	-		
	92		2. Эрүүл мэндийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх хүрээнд хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрт мэдээллийн технологийн аудитыг төрийн аудитын байгууллагаар гүйцэтгүүлж, төсөл хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах	-		
	93		3. Иргэдэд төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр хүргэх зорилгоор Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлж	-		

			байгаа "Цахим эрүүл мэнд" төслийг эрчимжүүлж эрүүл мэндийн байгууллагуудын мэдээллийн системийг цахим үйлчилгээний нэгдсэн систем /Е-МОНӨОША/-Д холбох асуудлыг судалж, хологдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх			
48	96	Засгийн газарт чиглэл өгөх тухай 2021-10-19 Дугаар 2021 №05	2.. Эрүүл мэндийн даатгалын санд төр хариуцан төлөх эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг үе шаттайгаар нэмэгдүүлэх, эрүүл мэндийн даатгалын сангийн зарцуулалтыг оновчтой болгох, төлөвлөлтийг сайжруулах, санг болзошгүй эрсдэлээс хамгаалах;	Хамаарахгүй		
	97		3.. Эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ, төлбөрийн хэмжээг Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл нь баталдаг байх, одоо мөрдөгдөж буй тушаал, шийдвэрийн зөрчлийг арилгах;	-		
	98		7. Хуулийн хүрээнд төрийн болон орон нутгийн өмчит төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, нэгдсэн эмнэлгийн засаглалыг хагас бие даасан тогтолцоонд шилжүүлэх, төлөөлөн удирдах зөвлөлүүдийг байгуулах ажлыг 2021 оны 12 дугаар сард багтаан дуусгах, Багануур, Баянгол, Налайх,			

			Чингэлтэй дүүргийн эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааг нэгдсэн эмнэлэг болгож, хагас бие даасан тогтолцоонд шилжүүлэх боломжийг бүрдүүлэх			
	101		14.. Эрүүл мэндийн байгууллагуудад ашиглагдаж байгаа программ хангамжуудыг нэгтгэж, нэн даруй нэгдсэн мэдээлэл солилцооны платформд шилжүүлэх, цахим хяналтыг сайжруулах	-		
	102		15.. Эрүүл мэндийн салбарын худалдан авах ажиллагааг бүрэн цахимжуулах, ил тод нээлттэй байдлыг хангах, хяналтыг сайжруулах	Тендерийн урилгыг http://tender.gov.mn/ сайт, байгууллагын цахим хуудас https://derma.gov.mn/ , өдөр тутмын “Өдрийн мэдээ” сонинд нийтэлж тендерт оролцогч нарт шалгарсан болон шалгараагүй мэдэгдлийг албан бичгээр болон төрийн худалдан авалтын http://tender.gov.mn/ сайтад үнэлгээний хорооны нарийн бичиг тухай бүрд нь нийтлэн ажилласан.		
50	105	Хүүхдийг тамхины хор хөнөөлөөс сэргийлэх зарим арга хэмжээний тухай 2022-05-11 Дугаар 2022 №06 БСШУСБХ	1.1/. Тамхины хяналтын тухай хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлж, бүх шатны боловсрол, сургалтын байгууллагын суралцагчдыг дам тамхидалтаас үүдэлтэй сөрөг үр дагавраас хамгаалах арга хэмжээ авах;	-		
	108		1.4/. хүүхдэд үйлчилдэг болон хүүхдийн чөлөөт цагаа өнгөрүүлдэг байгууллагыг тамхигүй орчин болгох, дам тамхидалтаас сэргийлэх чиглэлээр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх.	Эмнэлгийн гадна зориулалтын тамхины цэгийг 2021 онд байршуулан тамхигүй орчин бүрдүүлсэн.		

51	110	Чиглэл өгөх тухай 2022-06-07 Дугаар 2022 №14 НББХ	1.10. Ахмад настанд үзүүлж буй эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг (оношилгоо, эмчилгээний нэр төрөл, өрөө тасалгааны тоо хүртээмж, мэргэшсэн эмч, мэргэжилтний тоо) нэмэгдүүлэх;	Ахмад настнуудад амбулаторийн болон хэвтэн эмчлүүлэх тусламж үйлчилгээг тасралтгүй үзүүлж байна. Мэргэшсэн эмч, мэргэжилтний тоо -0		
52	112	Чиглэл өгөх тухай 2022-06-15 Дугаар 2022 №07 ҮББХ	1.4. Сүү, сүүн бүтээгдэхүүн нийлүүлэх, боловсруулах, үйлдвэрлэх, борлуулахад тээвэрлэхэд онцгой анхаарч, нийслэл орон нутгийн сургууль, цэцэрлэг, эмнэлэг болон төсөвт байгууллагуудыг тохирлын баталгаатай, эрүүл, аюулгүй сүү, сүүн бүтээгдэхүүнээр хангах, үйлдвэрлэгчдийг төрийн худалдан авалт, даатгалын сангийн зарцуулалтаар дэмжих ажлыг зохион байгуулах;	Хамаарахгүй		
53	113	Чиглэл өгөх тухай 2022-06-15 Дугаар 2022.06.15 №18 НББХ	1.1. Эмч, эмнэлгийн мэргэжилтний мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, анагаах ухааны дэвшилтэт техник, тоног төхөөрөмжөөр эмнэлгүүдийг хангах замаар Монгол Улсад оношлох, эмчлэх боломжгүй байгаа өвчнийг дотооддоо оношилж, эмчлэх боломжийг бүрдүүлэх;	-		
	117		1.5. Иргэдэд эрүүл, зөв амьдралын хэв маягийг төлөвшүүлэх, соён гэгээрүүлэх ажлыг тогтмол зохион байгуулах	Төвийн цахим хуудас www.derma.gov.mn болон байгууллагын Фэйсбүүк хуудсаар дамжуулан дараах мэдээ мэдээллийг байршуулсан. Үүнд: 1. Мэдээ, мэдээлэл -125 2.Нээлттэй ажлын байр – 60		

				3.Зөвлөгөө-Томуу томуу төст өвчлөл, арьс харшлын өвчлөл, халдварт өвчлөл зэрэг нийт 4 сэдвийн хүрээнд 230 гаруй зөвлөгөө оруулж ажилласан. 4.Эрүүл мэндийн тэмдэглэлт өдөр – 25 Байгууллагын фэйсбүүк болон цахим хуудсанд 800 гаруй мэдээ, мэдээлэл нийтэлсэн.		
	122		1.1.4/. асрамж, халамжийн төв, түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төвд ажиллах орон тооны сэтгэл зүйч, дохионы хэлний хэлмэрч, сэтгэл засалчийг ажиллуулах, онлайнаар тус үйлчилгээг авах нөхцөлөөр хангах;	Хамаарахгүй		
	125		1.1.6/. Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв дээр сэтгэцийн хурц эмгэг өөрчлөлттэй хүүхэд, эцэг эх, асран хамгаалагч нь тогтоогдохгүй байгаа, хагас, бүтэн өнчин хүүхдэд үйлчилгээ үзүүлэх бүтэц, орон тоог нэмэгдүүлэх;	Хамаарахгүй		
	127		За/. Засгийн газрын гадаад зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээ, өмч хөрөнгийн бүртгэл, хэрэгжилт, үр дүнд тавих хяналтыг сайжруулах, хэрэгжиж дууссан төслүүдийн хүрээнд үүссэн өмч, хөрөнгийн бүртгэлийг судлах, зээлийн эргэн төлөлтийн байдал, шинээр авахаар төлөвлөж буй зээлүүдийн эрэлт хэрэгцээг үнэлж, дүн шинжилгээ хийх, үр дүн	Засгийн газрын гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж буй төсөл, арга хэмжээ байхгүй.		

			муутай, хэрэгжилт удаашралтай төслүүд болон шинээр авахаар төлөвлөж буй шаардлагагүй гэж үзсэн зээлийг зогсоох, цаашид үргэлжлүүлэн хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг салбар бүрээр гаргах, танилцуулах;			
	128		бг/. төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, хяналтын бүх үе шатанд мэргэжлийн судлаачид, мэргэжлийн төрийн бус болон судалгааны байгууллагуудтай хамтран ажиллах.			
58	131	Засгийн газарт чиглэл өгөх тухай (ЁЗСХБХ) 2023-11-01 Дугаар 2023_10	1.2. Монгол Улсын Засгийн газар хуульд заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэн шийдвэр гаргахдаа төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжид заасан зарчим, нийтлэг хэм хэмжээ, шаардлагад нийцүүлж байх;			
	133		1.4. Иргэн төрийн албанд анх ороход тавих ёс зүйн шаардлагыг өндөрсгөх, ёс зүйн зөрчил гаргаж байсан хүнийг төрийн жинхэнэ албанд томилохгүй, албан тушаал дэвшүүлэхгүй байх зарчмыг хатуу мөрдөх;			
59	134	Монгол бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх ажлыг эрчимжүүлэх тухай 2018-05-23 Дугаар 2018_46	3.. Албан байгууллага, аж ахуйн нэгж, барилга байгууламж, гудамж, талбайн нэр хаяг, бүтээгдэхүүний шошго, бэлгэ тэмдэг, зар сурталчилгаа зэргийг	-		

			үндэсний бичгээр бичиж хэвшүүлэх ажлыг зохион байгуулах; үндэсний бичгийн хэрэглээг нэмэгдүүлж, түгээн дэлгэрүүлэхэд чиглэсэн уг үйл ажиллагаа, аливаа идэвх санаачилгыг хөхүүлэн дэмжиж, урамшуулж ажиллахыг бүх шатны Засаг дарга нар, холбогдох төрийн байгууллагуудад чиглэл болгосугай.			
60	135	Засгийн газарт чиглэл өгөх тухай 2019-04-09 Дугаар 2019_60	8. Хар тамхи, мансууруулах бодисоор өсвөр, залуу үеийг хордуулж байгаа нөхцөл байдлыг судлан, шалтгаан нөхцөлийг арилгах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх. Тайлбар: 2022 оны хагас жилийн тайланд хийсэн ХШҮ-ний дагуу энэхүү заалтыг ирүүлэхдээ дараах зүйлийг анхаарна уу: Шалтгаан нөхцөлийг арилгах чиглэлээр төлөвлөн хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар тусгах	-		
61	136	Засгийн газарт чиглэл өгөх тухай 2019-05-30 Дугаар 2019_104	1.12.. Монгол Улсын хэмжээнд амиа хорлох оролдлого хийсэн болон амиа хорлосон тохиолдлыг бүртгэх мэдээллийн сан бүрдүүлж, холбогдох байгууллагуудын нэгдсэн сүлжээтэй болсны үндсэн дээр хүн амд үзүүлэх сэтгэлзүйн тусламж үйлчилгээг хүртээмжтэй болгох Тайлбар: 2022 оны хагас жилийн тайланд хийсэн	-		

		ХШҮ-ний дагуу энэхүү заалтыг ирүүлэхдээ дараах зүйлийг анхаарна уу: Нэгдсэн мэдээллийн сан бий болгох талаар хийсэн ажлууд, түүний үр дүнд сэтгэл зүйн ямар тусламж үйлчилгээг үзүүлсэн, гарсан үр дүнг тусгах			
	137	1.13.. Иргэдийн нас баралтад нөлөөлж байгаа өвчин эмгэгийн байдалд судалгаа хийж, өвчлөлийг бууруулах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч, санхүүжилтийг шийдвэрлэх.	-		
	138	1.14. Эмийн худалдаа, чанар, хадгалалт, эргэлтэд тавих хяналтыг чангатгах.	2024 оны эхний хагас жилийн байдлаар тус төв эмчилгээнд хэрэглэгдэх нийт эм болон эмнэлгийн хэрэгсэл оношлуурыг 47 багц болгон төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу тендерийг нээлттэй цахим хэлбэрээр зохион байгуулж, гэрээгээр баталгаат эм ханган нийлүүлэх байгууллагуудаас худалдан авсан. Эмийг зориулалтын агуулахад стандартын дагуу зохистой хадгалдаг.		
	139	1.17.. Хүний эрүүл мэндэд нөлөөтэй эмийн бус бүтээгдэхүүн /чихэр, давс, хансан тос ихээр агуулсан хүнс, зохицуулах үйлчилгээний хүнс, биологийн идэвхт бүтээгдэхүүн, согтууруулах ундаа, тамхи/ - ийн тусгай зөвшөөрөл, бүртгэл, сав, баглаа боодол, шошгын танилцуулга, зар сурталчилгааг зохицуулах, хянах эрх зүйн зохицуулалтыг бий болгох.	Хамаарахгүй		

62	140	Засгийн газарт чиглэл өгөх тухай /Тэрбум мод/ 2021-10-04 Дугаар 2021_58	2. Энэ зарлигийг хэрэгжүүлэхэд идэвх санаачилгатай оролцож, эх байгалиа хайрлан хамгаалах, мод тарьж ургуулах үйлсэд бодит хувь нэмэр оруулахыг иргэд, аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллагуудад уриалсугай.	-			
63	141	Халдварт өвчний өнөөгийн байдал, хяналтыг сайжруулах талаар авах зарим арга хэмжээний тухай 2010-03-19 Дугаар 2010_11/06	1. 1. "Дархлаажуулалтын тухай", "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний тухай", "Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай" хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, вакцины нийлүүлэлт, эм, хүнсний зохицуулалтын бие даасан алба байгуулах, хөндлөнгийн хяналтыг тодорхой болгох, зарим эм, эмнэлгийн хэрэгсэл, вакцин тоног төхөөрөмжийг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн үйлдвэрээс шууд худалдан авах бололцоог бүрдүүлэх, улсын хэмжээнд вакцин, био бэлдмэлийн хөндлөнгийн хяналтын лаборатори байгуулах, төрийн хяналтыг чангатгах, хяналт шалгалтын тогтолцоог шинэчлэн боловсруулж, хэрэгжүүлэх,	Элэгний В, С вирус илрүүлэх шинжилгээнд 123 ажилтан, 16 резидент эмч нарыг хамруулснаас 12 ажилтанд С вирус эерэг, 3 ажилтанд В вирус эерэг үр дүн гарсан. Нийт хамрагдвал зохих 136 эмч, албан хаагчдаас 123 буюу 90.4% нь хамрагдсан.			
	142		2. 2. Биотехнологийн цогцолбортой болох, Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэнгийн биотехнологи,	Хамаарахгүй			

			иммуноглобулины үйлдвэрлэлийг дэмжих, товллын бус вакцин, био бэлдмэлийн үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулах зорилготой байгаа улсын байгууллага болон хувийн аж ахуйн нэгжийг төрийн зүгээс анхаарч, хууль, эрх зүйн хувьд дэмжин, хамтран ажиллах,			
64	143	Биоаюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай 2011-07-07 Дугаар 2011_25/24	1. Био аюулгүй байдлыг хангах урт хугацааны цогц бодлого бүхий үндэсний хөтөлбөр боловсруулан баталж, хэрэгжүүлэх	Хамаарахгүй		
	144		4. Био аюулгүй байдлыг хангах, урьдчилан сэргийлэх зорилготой био аюулгүй ажиллагааны гуравдугаар зэрэглэлийн лаборатори байгуулах санхүүжилтийг шийдвэрлэж, хэрэгжүүлэх	Хамаарахгүй		
	145		6. Молекул биологи, био анагаах, биотехнологи, нано технологийн чиглэлээр мэргэжилтэн бэлтгэх, тэдгээрт ажлын байрыг бодлогоор бий болгох	-		
	146		2. Био аюулгүй байдлыг хангах салбар дундын зохицуулалтыг боловсронгуй болгох, энэ чиглэлээр ажилладаг төрийн захиргааны болон судалгаа шинжилгээний байгууллагын чадавхыг бэхжүүлэх,	-		

	147		5. Хувиргасан амьд организмтай холбоотой шинжлэх ухаан, танин мэдэхүйн бүх нийтийн боловсрол, мэдлэг олгох сургалт сурталчилгааг эрчимжүүлэх,	-		
65	148	Эм вакцин, био бэлдмэлийн хангамж, нөөц - чанар тэдгээрийн аюулгүй байдалд тавих хяналт 2013-01-08 Дугаар 2013_03/03	2. Эмийн түгээлтийн шат бүрд эмийн үнийг хянах механизмыг бий болгох;	2024 оны эхний хагас жилд тендерийн гэрээгээр баталгаат эм, эмнэлгийн хэрэгсэл, оношлууруудыг татан авч хэрэглэж байна. Ehealth программаар эмийн захиалга хийгдэж, эмийн үнэ, өвчний түүхэнд бодогдон гардаг. Мөн сар бүрийн эмийг гэрээний дагуу худалдан авч, татан авалтын орлогын болон зарцуулалтын тайланг эмийн нягтланд гарган өгч ажилласан.		
	149		3. Бүсийн төвүүдэд болон эм, эмнэлгийн хэрэгсэл нэвтрүүлдэг хилийн боомтууд дээр эм, био бэлдмэлийн сорилын лаборатори байгуулах, шинжилгээний түргэвчилсэн арга нэвтрүүлж, хил гаалийн хяналтыг сайжруулах;	Хамаарахгүй		
	150		4. Цус сэлбэлт судлалын шинэ төвийн барилгыг шаардлагын хэмжээнд барих хэмжээний хөрөнгө /2,9 тэрбум төгрөг/ болон гамшгийн үеийн нөөц бүрдүүлэх, цус, цусан бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангахад шаардлагатай санхүүжилтийг шийдвэрлэх;	Хамаарахгүй		
	151		6. Биологийн идэвхт бүтээгдэхүүнийг сүлжээгээр борлуулж байгааг зогсоох,	-		

			эрх зүйн орчин бүрдүүлэх, эрүүл мэндийн ажилтнуудыг сурталчилгаа болон борлуулалтад оролцохыг хориглох			
66	152	Агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээг эрчимжүүлэх тухай 2014-10-20 Дугаар 2014_52/30	2.8. Агаарын бохирдлоос үүдэлтэй иргэний эрүүл мэндэд нөлөөлөх сөрөг нөлөөллийг үнэлэх, сөрөг нөлөөлөл болон өвчлөлийг бууруулах цогц арга хэмжээг үе шаттай авч хэрэгжүүлэх	-		
67	153	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх ажлыг эрчимжүүлэх тухай 2018-02-05 Дугаар 2018_06/05	1.2. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийн жагсаалтыг тагнуул, цагдаа, шүүхийн шинжилгээ, гааль, мэргэжлийн хяналтын болон холбогдох бусад байгууллагын саналыг авч НҮБ болон ДЭМБ-аас гаргасан жагсаалтыг үндэслэн тухай бүр шинэчлэн батлах санал боловсруулж, холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэх	-		
	154		1.7. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэгч, донтогчдын талаарх судалгааг гаргах, тэднийг албадан эмчлэх эмчилгээний арга зүй, стандартыг тогтоож, мэргэшсэн эмч, сэтгэл зүйч бүхий наркологийн төвийг байгуулах асуудлыг судалж, шийдвэрлэх.	Хамаарахгүй		

68	155	Хүнсний аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай 2022-05-02 Дугаар 2022_01	3.10.. Хоол, хүнсний зөв, зохистой, соёлтой хэрэглээний талаарх сургалт, сурталчилгаа, соён гэгээрүүлэх ажлыг улс орон даяар зохион байгуулах	Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвтэй хамтран 2024 оны 06 дугаар сарын 20-ний өдөр Арьс харшлын эмч У.Саруул "Хүнсний харшлын" талаар контент бэлтгэн олон нийтийн сүлжээгээр мэдээлэл хүргэсэн.		
69	156	Цар тахлын эсрэг био бэлдмэл, вакцин үйлдвэрлэх талаар авах арга хэмжээний тухай 2021-05-12 Дугаар 2021_144	3. Цаашид гарч болзошгүй цар тахлын эсрэг хариу арга хэмжээ авах зорилгоор "Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв"-ийн дэргэд Корона вирусийн эсрэг идэвхгүйжүүлсэн вакцины үйлдвэр, Вакцины хяналтын үндэсний лаборатори байгуулах тооцоо, судалгааг хийж, Засгийн газарт танилцуулахыг Эрүүл мэндийн сайд С.Энхболд, Сангийн сайд Б.Жавхлан нарт даалгасугай.	-		
70	157	Монгол хэлний тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2022-01-05 Дугаар 2022_7	5. Монгол хэлний тухай хуулийн хэрэгжилтийг хангах дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг төсвийн ерөнхийлөн болон шууд захирагч нарт тус тус даалгасугай: 5.1. эрх бүхий судалгааны байгууллагатай хамтран салбарын мэргэжлийн нэр томъёог орчуулах, шинээр үүсгэх, жигдлэх, толилох ажлыг зохион байгуулах, нийтийн хэрэглээнд нэвтрүүлэх; 5.2. төрийн байгууллагын цахим хуудас,	-		

			сонин хэвлэлд нийтэлж байгаа мэдээ, мэдээллийг 2022 оноос эхлэн кирилл, монгол бичгээр зэрэгцүүлэн нийтэлж хэвшүүлэх; 5.3. төрийн байгууллагын шийдвэр, албан бичгийг энэ тогтоолын 4-т заасан дүрэм, журам, заавар, стандартын дагуу хос бичгээр хөтлөх ажлыг турших; 5.4. төрийн албан хаагчдын монгол хэл, үндэсний бичгийн мэдлэг чадварыг дээшлүүлэх арга хэмжээ авах, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг жил бүр баталж мөрдүүлэх; 5.5. төрийн байгууллагын гадна болон өрөө тасалгааны хаяг, албан хаагчдын нэрийн хуудсыг монгол бичгээр үйлдэж, хэвшүүлэх.			
71	158	Хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний талаар авах зарим арга хэмжээний тухай 2022-09-14 Дугаар 2022_340	1. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, төр-хувийн хэвшлийн түншлэлийг өргөжүүлэх, бизнесийн үйл ажиллагаанд төрийн оролцоог багасгах зорилгоор төрийн зарим чиг үүрэг, ажил үйлчилгээг сонгон шалгаруулалтын үндсэн дээр зохих хууль журмын дагуу хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх арга хэмжээ авч ажиллахыг төсвийн ерөнхийлөн захирагч болон аймаг, нийслэлийн Засаг дарга нар, Төрийн	-		

			өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т тус тус үүрэг болгосугай.			
	159		3. Эрхлэх асуудлын хүрээнд хамаарах зарим чиг үүрэг, ажил үйлчилгээг хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх чиглэлээр шаардлагатай бол холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулах санал боловсруулж, хэлэлцүүлэхийг Засгийн газрын гишүүдэд даалгасугай.			
72	160	Хот, хөдөөгийн сэргэлтийн бодлогын хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай 2022-11-23 Дугаар 2022_419	5. Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байгаа харьяа төсөвт байгууллага, төрийн өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компани, түүний салбар, нэгж болон салбарын нийт албан хаагчдынхаа 10-аас доошгүй хувийг орон нутаг руу шилжүүлэх бодлогын чиглэл баримталж, үе шаттайгаар хэрэгжүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүдэд тус тус үүрэг болгосугай.	Тус төв нь төрөлжсөн нарийн мэргэшлийн эмч, сувилагч, эмнэлгийн мэргэжилтний хомсдолтой тул бодлогын хүрээнд хэрэгжилтийг хангах боломжгүй болно.		
74	162	Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай	2. Төсвийн хөрөнгө оруулалтын чиглэлээр дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай: 2.1.Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, төсвийн хөрөнгө оруулалтын сахилга	Төрийн хэмнэлтийн тухай хуулийг үйл ажиллагаанд чанд мөрдөж, үр ашиггүй зардал гаргахгүй байх, шилэн дансны мэдээллийг хуульд заасан хугацаанд бүрэн гүйцэд байршуулж хэвшүүлэхээр ажиллаж байна.		

		<p>2022-12-07 Дугаар 2022_448</p>	<p>бат, хариуцлага, үр ашгийг сайжруулах зорилгоор төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний зураг төсвийг санхүүжилтийн эх үүсвэр батлагдсан тохиолдолд боловсруулах; 2.2.төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны үр дүнд бий болсон хэмнэлтийг зарцуулахгүй байх; 2.3.төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг шуурхай зохион байгуулж, батлагдсан санхүүжилтийг төсвийн жилд багтаан бүрэн олгох арга хэмжээг авах; 2.4.Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд барилгын материалын үнийн өсөлтийн нэмэгдэл нь батлагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний үнийн өсөлтийг санхүүжүүлэхэд хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээний бэлтгэл ажил, зохион байгуулалтыг шуурхай зохион байгуулах; 2.5.Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, хэрэгжилт, гүйцэтгэл, санхүүжилт, хяналт болон тайлагналтын үйл ажиллагааг Сангийн яамны улсын төсвийн хөрөнгө оруулалтын</p>			
--	--	---------------------------------------	--	--	--	--

			удирдлагын цахим систем (PIMIS- www.publicinvestment.gov.mn)- ээр дамжуулан хэрэгжүүлж ил тод, нээлттэй байдлыг хангах.			
77	165	Хот, хөдөөгийн сэргэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай 2023-02-08 Дугаар 2023_68	5. Хот, хөдөөгийн сэргэлтийн зорилтыг хангах зорилгоор харьяа төсөвт байгууллага, төрийн өмчийн үйлдвэрийн газар, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компани, түүний салбар, нэгж болон салбарын нийт албан хаагчдын тодорхой хувийг орон нутагт шилжүүлэх ажлыг хэрэгжүүлэхэд зориулан 2023 оны батлагдсан төсвөөс 50.0 (тавин) саяас доошгүй төгрөгийг зарцуулах, цаашид уг зардлыг жил бүрийн улсын төсөвт тусгаж байхыг Засгийн газрын гишүүдэд үүрэг болгосугай.	-		
107	207	Засгийн газрын хүний нөөцийн бодлогыг дэмжих цахим системийн талаар авах арга хэмжээний тухай 2024-05-08 Дугаар 2024_196	3. “Засгийн газрын хүний нөөцийн бодлогыг дэмжих цахим систем”-ийг ашиглан эрхлэх асуудлынхаа хүрээндээ төрийн албан хаагчийн мэдээллийн бүрдүүлэлт, үнэн зөв байдалд хяналт тавьж ажиллахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай	Хүний нөөцийн цахим системд албан хаагчдын мэдээллийг тухай бүр нь шинэчлэн засаж, мэдээллийн бүрдүүлэлт хийж ажилласан.		
	213		ҮIII.5.1. . Хөдөлмөрийн тухай хуулийн 111 дүгээр зүйлд заасныг хэрэгжүүлж ажиллах,	Төвийн хэмжээнд төрөлхийн болон бусад төрлийн оноштой хөгжлийн бэрхшээлтэй 5 албан хаагч ажилладаг. Эдгээр албан хаагчид хөдөлмөрийн		

112		2021 оны 6 дугаар сарын 8-ны өдөр 34 дүгээр тэмдэглэл 2021-06-08 Дугаар 2021_34	энэ хүрээнд өөрийн эрхэлсэн салбарын төрийн захиргааны төв байгууллага болон төрийн захиргааны байгууллагад нэг буюу түүнээс дээш тооны хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажиллуулах зохион байгуулалтын арга хэмжээ авахыг Засгийн газрын нийт гишүүдэд; ("Хөгжлийн бэрхшээлтэй хүний талаар 2021-2024 онд авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний талаар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяа Засгийн газрын гишүүдэд танилцуулав.)	тухай хуулийн 111 дүгээр зүйлд тусгасны дагуу ажиллах нөхцөлтэй нь уялдуулан хоргодуулсан цагаар ажиллах зохион байгуулалттай. Мөн бүтэн цагаар ажилладаг ажилтны цалин хөлсний хэмжээнээс бууруулаагүй болно.		
	214		ҮIII.5.2 . Хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн харилцаанд оролцох тэгш эрхийг хамгаалж, холбогдох хууль тогтоомж, стандартын хэрэгжилтийг эрхэлсэн салбар, харьяалах нутаг дэвсгэртээ хангуулах, хяналт тавьж ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт;	Байгууллагын 2022-2025 онд хэрэгжүүлэх Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөрт хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай сургалтыг үе шаттай зохион байгуулахаар төлөвлөсөн. Байгууллагын цахим, вэб хуудас болон фейсбүүк группт хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн заалтууд, гарын авлага, танилцуулах хуудас байршуулсан. Эмч, эмнэлгийн албан хаагчид олон нийтийн сүлжээнд хөгжлийн бэрхшээлтэй хүний тухай мэдээ мэдээллийг өөрийн фейсбүүк хуудсанд хуваалцаж, мэдээ, мэдээллийг түгээж байна.		
125	228	2022 оны 6 дугаар сарын 15-ны өдөр 33 дугаар тэмдэглэл	XIII.1. . Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн талаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, өнөөгийн	Хамаарахгүй		

		<p>2022-06-15 Дугаар 2022_33</p>	<p>нөхцөл байдлын талаар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяа Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан: 1. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах, хамгаалахтай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэл, дүүргийн Засаг дарга нарт даалгав: 1.1. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах дэд болон салбар зөвлөлийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, хяналт тавих, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын үйл ажиллагааг зохих журмын дагуу дэмжиж ажиллах; 1.2. Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 6 дугаар сарын 8-ны өдрийн хуралдааны 34 дүгээр тэмдэглэлээр өгсөн үүрэг, даалгаврын хэрэгжилтийг эрчимжүүлэх; 1.3. хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн нийгмийн харилцаанд тэгш оролцох эрхийг хангах, хамгаалах хүрээнд холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг эрхэлсэн салбар, харьяалах нутаг дэвсгэртээ хангуулж, хяналт тавьж ажиллах.</p>			
--	--	--------------------------------------	--	--	--	--

	229		<p>XIII.1.2. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, сайжруулах хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Эрүүл мэндийн сайд С.Энхболдод даалгав: 2.1. тархины саа, саажилт, уналт таталттай хүүхдийн уналт таталтын эсрэг эм хангамжийн нөхцөл байдлыг судалж, шаардлагатай эм, бэлдмэлийг бүртгэлжүүлж, нэр төрлийг нэмэгдүүлэх, төлбөрийг төрөөс хариуцах эмийн жагсаалтад оруулах, яаралтай горимоор хангах талаар холбогдох арга хэмжээ авах; 2.2. ховор тохиолддог өвчин, эмгэгийг эмчлэх болон гамшиг, гамшгийн онцгой нөхцөл байдал үүссэн үед шаардагдах эм, эмнэлгийн хэрэгсэл, урвалж оношлуур, эмнэлгийн тоног төхөөрөмж, түүний дагалдах хэрэгслийн худалдан авалт, ханган нийлүүлэлт, нөөц, бэлэн байдлын асуудал хариуцсан байгууллагыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын харьяанд байгуулах эсэх асуудлыг судалж саналаа Засгийн газарт танилцуулах;</p>	Хамаарахгүй		
--	-----	--	--	-------------	--	--

			<p>2.3. хүүхдийн өвчин, эмгэг, хавдар, хөгжлийн хоцрогдол, бэрхшээлийн тархвар зүй, шалтгаан, хэрэгцээний талаар судалгаа хийж, өвчин, эмгэг, хөгжлийн бэрхшээлтэй болохоос урьдчилан сэргийлэх, эмчийн хандлага, харилцаа, эмийн болон бусад эмчилгээг олон улсын түвшинд хүргэхэд чиглэсэн шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх; 2.4. бүх шатанд хүүхдийн мэдрэлийн эмгэгийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, эмчилгээ, үйлчилгээний үр дүнг үнэлэх, нарийн мэргэжлийн эмчийг чадавхжуулах талаар зохих арга хэмжээ авах; 2.5. Монгол Улсад эмчлэх боломжгүй хүүхдийн өвчин, эмгэгийг гадаадын эмчилгээний багтай хамтран эх орондоо эмчлэх боломж, нөхцөлийг судалж, мэс засал яаралтай хийлгэх шаардлагатай зарим хүүхдийн асуудлыг 2022 оны 9 дүгээр сард багтаан нэн тэргүүнд шийдвэрлэх, эмчилгээний арга технологийг нутагшуулах замаар эмнэлгийн мэргэжилтнийг чадавхжуулах; 2.6. хүүхдийн хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэх,</p>			
--	--	--	--	--	--	--

		<p>оношлох, үнэлэх, урьдчилан сэргийлэх, эмчлэх, сувилах, сэргээн засахад шаардлагатай хүний нөөц, оношилгооны лаборатори, тоног төхөөрөмж, эм, эмнэлгийн хэрэгслийн тооцоо судалгааг гаргаж, шаардагдах хөрөнгийг шийдвэрлэх талаар холбогдох арга хэмжээ авах.</p>			
	230	<p>XIII.1.4. Хөгжлийн бэрхшээлтэй хүнд үзүүлэх нийгмийн халамж, хөгжлийн үйлчилгээг сайжруулахтай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэл, дүүргийн Засаг дарга нарт даалгав: 4.1. байнгын асаргаа шаардлагатай 18 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч, ажил хөдөлмөр эрхлээгүй байгаа эцэг, эсхүл эх, хууль ёсны асран хамгаалагчийн эрүүл мэндийн даатгалын болон тэтгэврийн даатгалын шимтгэлийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс тооцож улсын төсвөөс төлөх боломжийг судлан саналаа шаардагдах зардлын тооцооллын хамт танилцуулахыг Сангийн сайд Б.Жавхлан, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяа, Эрүүл мэндийн сайд С.Энхболд нарт; 4.2.</p>	Хамаарахгүй		

			<p>Нийгмийн халамжийн сангаас олгож байгаа хөдөлмөрийн чадвараа 50 ба түүнээс дээш хувиар алдсан 16 насанд хүрсэн хөгжлийн бэрхшээлтэй иргэний тэтгэвэр болон эмнэлгийн хяналтад байдаг, байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тэтгэмжийн хэмжээг 288,000 төгрөгөөр үргэлжлүүлэн олгох болон цаашид уг хэмжээг инфляцын түвшинтэй уялдуулан нэмэгдүүлэх боломжтой эсэхийг судалж, зохих арга хэмжээ авч ажиллахыг Сангийн сайд Б.Жавхлан, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяа нарт; 4.3. хөгжлийн бэрхшээлтэй хүнд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх хүрээнд шаардлагатай хүний нөөцийн судалгааг хийж, дутагдалтай байгаа мэргэжилтнийг 2022-2023 оны хичээлийн жилээс эхлэн үе шаттайгаар бэлтгэх, сургалтын орчин, материаллаг баазыг бэхжүүлэх арга хэмжээ авахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Эрүүл мэндийн сайд С.Энхболд нарт; 4.4.</p>			
--	--	--	---	--	--	--

			<p>хөгжлийн бэрхшээлтэй хүнд эмнэлгийн тусламж, үйлчилгээг үзүүлдэг эмнэлгийн мэргэжилтний урамшууллыг нэмэгдүүлэх асуудлыг судалж, шаардлагатай хөрөнгийг шийдвэрлэх талаар холбогдох арга хэмжээ авахыг Сангийн сайд Б.Жавхлан, Эрүүл мэндийн сайд С.Энхболд нарт; 4.5. хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг, эх, хууль ёсны асран хамгаалагчийг хүүхдээ асрах, хөгжүүлэх, дэмжих чиглэлийн богино хугацааны сургалтад хамруулж, энэ чиглэлээр хөдөлмөр эрхлэх, цаашид мэргэжил эзэмшихэд нь холбогдох хууль тогтоомжийн дагуу дэмжлэг үзүүлж ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяа, Эрүүл мэндийн сайд С.Энхболд нарт; 4.6. хөгжлийн бэрхшээл, эрүүл мэндийг үнэлэх Үйлдлийн олон улсын ангилал (ICF)-ыг нэвтрүүлэх ажлыг эрчимжүүлэхийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяа, Эрүүл мэндийн сайд С.Энхболд нарт; 4.7. эцэг, эх, хууль ёсны асран хамгаалагчгүй, байнгын</p>			
--	--	--	---	--	--	--

			<p>асаргаа шаардлагатай сэтгэцийн хүнд хэлбэрийн эмгэгтэй, оюуны хөгжлийн бэрхшээлтэй хүний асрамжийн үйлчилгээ үзүүлдэг төрөлжсөн асрамжийн газрыг Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн дэргэд байгуулах асуудлыг судалж, шаардагдах санхүүжилтийг Монгол Улсын 2023 оны төсвийн төсөлд тусгах арга хэмжээ авахыг Сангийн сайд Б.Жавхлан, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяа, Эрүүл мэндийн сайд С.Энхболд нарт; 4.8. хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төвийн эрүүл мэнд, сэргээн заслын цогц тусламж, үйлчилгээг өргөжүүлж, мэргэжил, арга зүй, хүний нөөц, эм хэрэгсэл, багаж, тоног төхөөрөмжөөр хангах, үйл ажиллагааны чанар, үр дүнг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд авч хэрэгжүүлэхийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяа, Эрүүл мэндийн сайд С.Энхболд нарт;</p> <p>4.9. харьяалах нутаг дэвсгэрийнхээ хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд эрүүл мэндийн болон нийгмийн сэргээн засах тусламж,</p>			
--	--	--	---	--	--	--

			<p>үйлчилгээ үзүүлдэг, тэдний хөгжлийг дэмжих чиглэлээр ажилладаг төрийн бус байгууллагад хууль тогтоомжийн хүрээнд үйл ажиллагааны болон санхүүгийн дэмжлэг үзүүлж, хамтран ажиллахыг аймаг, нийслэл, дүүргийн Засаг дарга нарт, 4.10. бага орлоготой, байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, гэр бүлийн гишүүнтэй өрхийн орон сууцны хангамж, нөхцөлийг судлан сайжруулах шаардлагатай арга хэмжээ авч ажиллахыг Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт.</p>			
126	231	<p>2022 оны 6 дугаар сарын 22-ны өдөр 34 дүгээр тэмдэглэл 2022-06-22 Дугаар 2022_34</p>	<p>XII.8.3. Улаанбаатар хотоос хөдөө рүү шилжин амьдрах асуудлыг дэмжих, орон нутагт амьдрахын давуу талыг сурталчлах, олон нийтийн нөлөөллийн арга хэмжээг өрнүүлэх асуудлыг хамтран судалж, саналаа танилцуулахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяа, Эдийн засаг, хөгжлийн сайдын үүрэг хариуцагч Б.Жавхлан, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Эрүүл мэндийн сайд С.Энхболд нарт даалгав.</p>	Хамаарахгүй		

132	239	2022 оны 11 дүгээр сарын 9-ний өдөр 54 дүгээр тэмдэглэл 2022-11-09 Дугаар 2022_54	III.2. Иргэдэд хоол, хүнсний илчлэг (калори)-ийн талаар ойлголтыг олгож зохистой хэрэглээг бий болгох, эртэч, бүтээлч, эерэг, зөв хандлагатай эрүүл амьдралын хэмнэлийг бий болгох зорилгоор үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлж, хэрэгжүүлэх талаар хамтран шуурхай ажиллаж, дүнг танилцуулахыг Монгол Улсын сайд, Олимп, нийтийн биеийн тамир, спортын Үндэсний хорооны дарга Б.Бат-Эрдэнэ, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Т.Аюурсайхан, Соёлын сайд Ч.Номин, Эрүүл мэндийн сайд С.Энхболд нарт даалгав.	-		
133	240	2022 оны 12 дугаар сарын 7-ны өдөр 58 дугаар тэмдэглэл 2022-12-07 Дугаар 2022_58	XXI.6.1. Төрийн байгууллагын баримт бичгийг цахим хэлбэрээр солилцох нөхцөлийг бүрдүүлсэн талаар Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан: 1. Албан бичиг солилцооны дундын системийг ашиглах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч, албан баримт бичгийг цахим хэлбэрээр солилцож ажиллахыг Засгийн	Төрийн байгууллага хооронд цахимаар албан бичиг солилцохдоо able программыг ашиглаж байна.		

			газрын гишүүд, бүх шатны Засаг дарга, бүх шатны төрийн байгууллагын удирдлагад үүрэг болгов;			
136	246	2023 оны 2 дугаар сарын 1-ний өдөр 6 дугаар тэмдэглэл 2023-02-01 Дугаар 2023_6	XIY.1.3. Төрийн байгууллагууд болон зөвлөх үйлчилгээний захиалгаар хийлгэсэн судалгааны ажлын тайланг судалгааны нэгдсэн сангийн системд байршуулах, хянах, засварлах, хэрэглэгчийн саналыг хүлээн авах ажлыг холбогдох албан тушаалтанд хариуцуулж ажиллуулахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга болон аймаг, нийслэлийн Засаг дарга нар, төрийн болон төрийн өмчийн оролцоот хуулийн этгээд, компани, үйлдвэрийн газрын удирдлагад;	2023 онд судалгаа, эрдэм шинжилгээний мэдээллийг судалгааны нэгдсэн сангийн системд байршуулсан. 2024 онд системд байршуулах судалгаа эрдэм, шинжилгээний ажлын жагсаалтыг ЭМЯ-нд 2024 оны 06 дугаар сарын 17-ний 01/287 дугаар албан бичгээр илгээсэн. 2024 онд 1 судалгааны ажлын тайланг оруулахаар бэлтгэл хангагдсан, системийн үйл ажиллагаатай холбоотойгоор системд оруулаагүй болно.		
	252		III.5. Авлигатай тэмцэх жилийн хүрээнд авлигыг таслан зогсоох, хүнд суртлыг арилгах чиглэлээр хариуцсан салбар бүрдээ тодорхой арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын гишүүдэд даалгав.			
145	270	2023 оны 4 дүгээр сарын 19-ний өдөр 17 дугаар тэмдэглэл 2023-04-19 Дугаар 2023_17	XIX.2.3. Хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн зөрчлийг арилгуулахаар Хүний эрхийн үндэсний комиссын гишүүнээс гаргасан шаардлага, зөвлөмжийг биелүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүд болон бүх	Хамаарахгүй		

			шатны Засаг дарга нарт тус тус үүрэг болгов			
148	274	2023 оны 5 дугаар сарын 31-ний өдөр 23 дугаар тэмдэглэл 2023-05-31 Дугаар 2023_23	XXII.2.. “Шил ажиллагааны хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай” Монгол Улсын Ерөнхий сайдын 2023 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 01 дүгээр албан даалгаврын хэрэгжилтийн талаар Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан дараах арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, холбогдох мэдээлэл хариуцагч байгууллагын удирдлагуудад тус тус үүрэг болгов: 1.Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан байнга ил тод, нээлттэй байлгах мэдээллийг өөрийн байгууллагын цахим хуудаст, шаардлагатай мэдээллийг нэгдсэн систем (shilen.gov.mn)-д байршуулж, тухай бүр шинэчилж ажиллах; 2.Нээлттэй мэдээллийн нэгдсэн систем (shilen.gov.mn)-д мэдээллийг шууд холбох боломжтой байдлаар өөрийн байгууллагын системийн бэлэн байдлыг хангах; 3.Мэдээллийн сан, системийн хэвийн үйл ажиллагаа болон мэдээллийн үнэн зөв,			

			алдаагүй байдлыг бүрэн хариуцах.			
	291		2.25.. Эрүүл мэндийн даатгалаар олгогддог хөнгөлөлттэй эмийн чанарыг сайжруулах, нэр төрөл, тоо хэмжээг нэмэгдүүлэх, эрүүл мэндийн байгууллага болон шатлал хооронд үйлчлүүлэгчийг шилжүүлэх журамд нэмэлт, өөрчлөлт оруулан иргэдэд хүндрэлгүй байдлаар зохион байгуулах арга хэмжээ авахыг Эрүүл мэндийн сайд С.Чинзоригт;	Хамаарахгүй		
	302		XI.5.1. Аймаг, нийслэл, дүүрэг, сум дундын эмнэлэгт мэргэжлээс шалтгаалсан өвчний үзлэг хийх, сэргээн засах кабинет ажиллуулах, мэргэжлээс шалтгаалсан өвчин судлалын шинэ эмнэлгийн үйл ажиллагааг 2024 оны 2 дугаар улиралд багтаан эхлүүлэх талаар зохих арга хэмжээ авч ажиллахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяа, Эрүүл мэндийн сайд С.Чинзориг нарт;	Хамаарахгүй		
	303		XI.5.2. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар хороо, орон нутгийн зөвлөлийн үйл ажиллагааг идэвхжүүлж, ажлын уялдаа холбоог сайжруулах, боловсрол, эрүүл мэнд, үйлдвэр, үйлчилгээ, хөдөө аж ахуйн салбаруудад тохирсон	Хамаарахгүй		

			хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн бодлого боловсруулж хэрэгжүүлэх, ажилтныг стандартад нийцсэн ажлын хувцас, тусгай хамгаалах хэрэгслээр хангах үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэлийн үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагад дэмжлэг үзүүлж ажиллахыг Засгийн газрын холбогдох гишүүдэд даалгав			
	333		37.4.9. Нийслэл Улаанбаатар хотын агаарын чанарын бүсэд үйл ажиллагаа явуулж байгаа төсвийн байгууллага болон төрийн өмчит үйлдвэрийн үйлдвэрийн газруудын уурын зуухнуудад технологийн өөрчлөлт хийж, түүхий нүүрсний хэрэглээг бүрэн зогсоох зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаяр, Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр, Эрүүл мэндийн сайд С.Чинзориг нарт;	Хамаарахгүй		
174	341	2024 оны эхний хагас жилд хэрэгжилтийг эрчимжүүлэх төсөл, арга хэмжээний тухай 2024-01-12 Дугаар 2024_01	7.15. Нэг эх үүсвэрээс эм худалдан авах, эмийн нэгдсэн худалдан авалтын хэлцлээр дамжуулан чанартай эмийн нийлүүлэлтийг нэмэгдүүлэх (Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуульд өөрчлөлт оруулах) арга хэмжээг 2024			

			оны 1 дүгээр улиралд авч ажиллахыг Эрүүл мэндийн сайд С.Чинзоригт;			
--	--	--	--	--	--	--

-oOo-